

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

| | | | |
|---|----------------------|---------------------|-----------|
| Ярилцлага өгөгчийн нэр | Лувсанбалдан | Дугаар | L143 |
| Оршин суугаа аймаг | Улаанбаатар | Оршин суугаа сум | Хан-Уул |
| Төрсөн газар | Сүхбаатар | Төрсөн он | 1921 |
| Ажил мэргэжил | Өндөр настан | | |
| Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд | Гүн худгийн хийд | Сүм хийдийн дугаар | СБНР 013 |
| Одоогийн сүм хийд | | Сүм хийдийн дугаар | |
| Ярилцлага авсан он сар өдөр | 2007 оны 9-р сарын 4 | Ярилцлага авсан хүн | Ж.Одгарьд |

Сүхбаатар аймгийн Наран сумын Гүн худгийн хийд

Сүхбаатар аймгийн Наран сумын нутагт Гүн худаг гэдэг газар байгуулагдсан хийдийг Эрдэнэ-Өлзийт гэдэг байв.Тус хийд нь дөрвөлжин орой бүхий дугантай ,түүнтэй залгаа оройдоо шармал алтан хорол,жанцан,хос бодь гөрөөс бүхий мүхлиг хэлбэрийн том саравчтай байжээ.Дуганы урдаа арваад метр урт зургаа долоон метр өргөн чулуугаар өнгөлсөн талбайтай чанх хойно нь Зуугийн сүм хэмээх майхан нуруутай сүм байсан юм. Дуган Зуугийн сүм хоёрын харалдаа дунд нь майхан нуруутай хоёр сүмийн хаалгыг баруун,зүүн тийш харуулан барьсан байжээ.Сүмүүдийг хөх тоосгоор барьсны хамт хэрмийг мөн тоосгоор барьж,шавардаад шохойдон ягаан өнгийн зосоор будаснаас улаан хэрэм гэлцэнэ.Хэрмийн үүдний хаалга өргөн бөгөөд дээр нь майхан нуруутай хөх ваараар хээ угалз гарган чимсэн байв. Их дуганы баруун,зүүн жигүүрт дөрвөн талдаа хөх тоосгоор дугуй хэлбэрийн цонх гаргасан 3-4 орчим ам метр талбай бүхий дөрвөн метр өндөр тоосгон хананы дундаас дээш гарсан дөрвөн модон багана дээр майхан хэлбэрийн тоосгон дээврийг гоёмсгоор үйлдэж,ардаас нь том ширмэн хонх дүүжилсэн байсан аж. Тэр хонхны дорхи давцан дээр жил бүрийн намрын хурлын өдрүүдийн орой цагаар хоёр лам бишгүүр хангинуулан эгшиглүүлж,дуганы үүдэнд үхэр бүрээ хосоор сүр бадруулан дуугарах нь сүжигтнүүдийн итгэл сүсгийг улам лавшруулдаг байсан гэнэ.

Улаан хэрмийн урд хос чига, түүнээс урагш ямпай,улаан хэрмээс зүүн тийш жасын цагаан хэрэм байсны дотор 10гаруй метр урт чулуун довжоотой цагаан байшин байх бөгөөд нэг талд нь лам нарын цав (хоол),манж (цай)бэлтгэдэг нөгөө талд нь нярвуудын ажлын тасалгаа,агуулах оршино. Түүнээс урагш чулуун хашаанд хувилгаан лам Жамъянпэрэнлэй,Лувсаншаравын хоёр жан байшин байсны хамт улаан хэрмийн баруун хэсэгт Цогчин унзад Товуугийн Жамбын чулуун хашаа байшин,хамар тасалгаа гаргасан намхан шавар хашаанд гэрүүд багтаж ядан байрласан байв.Хийд нэлээд хожуу үе хүртэл Төв гаралтай Чамхар гэгээнийг шүтэж байсан бөгөөд тэрхүү гэгээн нь хөдөө гэр малын ажил эрхлэж байв.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Эрдэнэ-өлзийтийн хийд нь Ламрим дацантай өдөр бүр Цогчин, жасаа хурж, хавар Нүннай, зун нь хайлан, намар, өвөл нь зургаан ерөөл, есөн догшид, 36 магтаал хурж, цагаан сарын шинийн нэгэнд зуугийн сүмийн үүдэнд зогсоогоор Цэдэр хурдаг байв.

1937 оны гуравдугаар сард Эрдэнэ-Өлзийтийн хийд уг байрлалаас нүүж Их булагийн хийдтэй нийлжээ Эрдэнэ-Өлзийтийн эзгүйрсэн сүм дуган, жасын байшинг дээд газрын шийдвэрээр Дарьгангын хилийн отрядод шилжүүлсэн байна.